



“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ



Улаанбаатар хот
2024он

“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД:

“АТАР ӨРГӨӨ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн 14.00 цагт УБ, Хан уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-20, компанийн өөрийн байрны хурлын танхимд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2024 оны 04-р сарын 05 ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

- Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Ноогдол ашиг хувиарлах эсэх тухай хэлэлцэн батлах
- Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах
- ТУЗ болон ТУЗ –ийн дэргэдэх хороодын гишүүдийг сонгох,
- ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын төсөвийг тогтоох

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй мэйл хаяг болон утсаар холбогдон танилцах боломжтой.

Хаяг: УБ, Чингэлтэй дүүрэг, 3 хороо, УИД-ын ард 1-р байр “Аргай бэст” ҮЦК ХХК

Утас: 11-327026, 9919-5753

Мэйл хаяг: argaibest27@gmail.com

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“АТАР ӨРГӨӨ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай Тогтоолын Хавсралт-01

**“ АТАР ӨРГӨӨ ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГИЙН ТӨСӨЛ**

№	Хэлэлцэх асуудал	Шийдвэрийн төсөл	Хугацаа	Хариуцагч
1	Хурлын ирцийг бүртгэх.		13:30-13:55	Тооллогын комисс
2	Хурлын ирцийн дүнг гаргах, танилцуулах		13:55-14:00	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах.		14:00-14:05	Хурлын дарга Б.Мөнхдалай
4	Хурлаар хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу уншиж, танилцуулах		14:05-14:10	Хурлын дарга Б.Мөнхдалай
5	Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт		14:10-14:15	Компанийн санхүүгийн алба
6	Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:15-14:20	Гүйцэтгэх захирал
7	Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:20-14:25	Гүйцэтгэх захирал
8	Ноогдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн, батлах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:25-14:30	ТУЗ-ын дарга Б.Мөнхдалай
9	ТУЗ болон ТУЗ –ийн дэргэдэх хороодын гишүүдийг сонгох	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:30-14:35	Хурлын дарга Б.Мөнхдалай
10	ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын дүнг тогтоох	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:35-14:40	Хурлын дарга Б.Мөнхдалай
11	Бусад		14:40-14:45	Хурлын дарга Б.Мөнхдалай
12	Асуулт, хариулт		14:45-15:00	
13	Хэлэлцэх асуудлаар санал, хураалт		15:00-15:05	
14	Хурлын завсарлага.		15:05-15:10	
15	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах		15:10-15:15	Тооллогын комисс
16	Хурлыг хурлын дарга хаана.		15:15-15:20	Хурлын дарга Б.Мөнхдалай

“АТАР ӨРГӨӨ ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ

“Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурал 2024 оны 04-р сарын 26-ны өдөр зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна:

1. “Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 26-ны өдөр зарлан хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоолын төсөл болон хавсралтууд
2. Компанийн санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт
3. Ноогдол ашиг хувиарлах эсэх тухай хэлэлцэн батлах
4. Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан
5. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах
6. ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох
7. ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын дүнг тогтоох
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны загвар
9. Ээлжит хурал зарлан хуралдуулахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл.

Дээрх бичиг баримттай хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд доорхи мэйл хаяг болон утсаар холбогдон танилцах боломжтой.

Хаяг: УБ, Чингэлтэй дүүрэг, 3 хороо, УИД-ын ард, 1-р байр “Аргай бэст ҮЦК” ХХК

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Утас: 11-327026, 9919-5753

Ажиллах цаг: Даваа - Баасан. 11.00-16.00



АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

20 24 оны 03 сарын 13 өдөр

№ 03

Улаанбаатар хот

“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН
ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын “Компанийн тухай хууль” болон СЗХорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн 14.00 цагт УБ, Хан уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-20, компанийн хурлын танхимд хуралдуулсугай.

2. “Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:

- Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
- Ноогдол ашиг хувиарлах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн, батлах
- Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах
- ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох
- ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын дүнг тогтоох
- Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04-р сарын 05-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Мөнхдалайг, тооллогын комиссын даргаар “Аргай бэст ҮЦК” ХХК /Гүйцэтгэх захирал Л.Гантуяа/- гишүүнээр Ц.Сайнжаргал, Л.Гантөгс нарыг тус тус томилсугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 03-р сарын 15-ны дотор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр /өдөр тутмын 2-с доошгүй сонин/ болон компани арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар мэдээлэх.

Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээллэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах коммист “Аргай бэст ҮЦК” ХХК /Гүйцэтгэх захирал Л.Гантуяа/-д даалгасугай.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01-р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь 02-р хавсралтад заасан бичиг баримттай argaiBEST27@gmail.com хаягаар буюу ажлын өдрүүдэд “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн 11-327026, 9919-5753 утсаар холбогдон танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудсын агуулгыг 03-р хавсралтаар баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтоосугай.

9. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Атар-Өргөө” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст “Аргай бэст ҮЦК” ХХК /Гүйцэтгэх захирал Л.Гантуяа/-д даалгахаар тогтоосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Б.МӨНХДАЛАЙ

Атар-Өргөө ХК-ний 2023 он
Ерөнхий ба удирдлагын зардалийн гүйцэтгэл

№	Ерөнхий ба удирдлагын зардал	Мян.тог		
		Төлөвлөгөө-2023 он	Гүйцэтгэл-2023 он	Гүйцэтгэл хувь
1	Ажилчдын цалин хөлс, купон, хоол унааны зардал	626,251.67	460,504.94	73.5%
2	Ажилчдын шагнал, урамшуулалын зардал	22,000.00	22,000.00	100.0%
3	Байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал	141,700.08	70,470.33	49.7%
4	Албан татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн зардал	12,454.80	3,188.82	25.6%
5	Томилолтын зардал	10,000.00	2,148.48	21.5%
6	Бичиг хэргийн зардал	4,230.95	5,673.16	134.1%
7	Шуудан холбооны зардал	12,982.01	10,314.10	79.4%
8	Мэргэжлийн үйлчилгээний зардал	8,106.69	8,325.11	102.7%
9	Ажилчдын сургалт, заавар, чиглүүлэг, хурал, уулзалтын зардал	1,000.00	1,536.36	153.6%
10	Даатгалын зардал	1,500.00	334.59	22.3%
11	Ашиглалтын зардал	18,231.59	9,049.25	49.6%
12	Засварын зардал	35,957.49	9,811.18	27.3%
13	Элэгдэл, хорогдлын зардал	131,795.23	141,054.95	107.0%
14	Түрээсийн зардал	1,000.00	-	0.0%
15	Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалт, дотоод хэрэгцээний зардал	15,256.26	2,271.90	14.9%
16	Тээврийн зардал	500.00	699.00	139.8%
17	Шатахууны зардал	8,318.70	3,677.35	44.2%
18	Зар сурталчилгааны зардал	1,051.83	1,368.02	130.1%
19	Хөдөлмөр хамгаалалын зардал	7,716.76	9,573.61	124.1%
20	ЕУЗ Эм, тариа, түргэн тусламж	2,779.86	5,773.00	207.7%
21	Хангамж БҮТЭЗ	25,627.13	25,628.46	100.0%
22	Бизнес уулзалтын зардал	3,000.00	3,000.00	100.0%
23	Ажилчдыг идэвхижүүлэх болон баяр ёслол, уралдаан тэмцээний зардал	4,000.00	3,769.64	94.2%
24	Бэлэг дурсгалын зардал	10,960.88	14,588.00	133.1%
25	Банкны шимтгэл зардал	2,839.79	1,349.00	47.5%
26	Дээж шинжилгээтэй холбоотой зардал	2,926.86	4,823.00	164.8%
27	Бараа материалын хорогдол	1,500.00	145.00	9.7%
	Нийт	1,113,688.57	821,077.27	73.7%

Атар-Өргөө ХК-ний 2023 он
Борлуулалт, маркетингийн зардалийн гүйцэтгэл

№	Борлуулалт, маркетингийн зардал	Мян.төг		
		Төлөвлөгөө-2023 он	Гүйцэтгэл-2023 он	Гүйцэтгэл хувь
1	Ажилчдын цалин хөлс, купон, хоол унааны зардал	839,435.14	742,451.91	88%
2	Ажилчдын шагнал, урамшуулалын зардал	10,000.00	10,000.00	100%
3	Байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал	103,211.84	91,817.17	89%
4	Хуулийн дагуу аж ахуй нэгжээс төлсөн тэтгэмжийн зардал	1,000.00		0%
5	Албан татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн зардал	23,388.76	55,087.79	236%
6	Томилолтын зардал	12,910.61	7,619.83	59%
7	Бичиг хэргийн зардал	7,413.27	8,054.38	109%
8	Шуудан холбооны зардал	17,374.82	19,264.47	111%
9	Мэргэжлийн үйлчилгээний зардал	17,708.43	23,578.70	133%
10	Ажилчдын сургалт, заавар, чиглүүлэг, хурал, уулзалтын зардал	2,000.00	1,180.64	59%
11	Даатгалын зардал	14,743.14	8,599.75	58%
12	Ашиглалтын зардал	39,304.54	25,424.14	65%
13	Засварын зардал авто	153,093.40	77,978.72	51%
14	Элэгдэл, хорогдлын зардал	159,714.65	151,828.33	95%
15	Түрээсийн зардал	57,835.47	57,977.63	100%
16	Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалт, дотоод хэрэгцээний зардал	46,784.59	36,021.61	77%
17	Тээврийн зардал	462.00	462.00	100%
18	Шатахууны зардал	298,502.23	168,216.42	56%
19	Харилцагчийн урамшуулал, идэвхижүүлэлтийн зардал	3,000.00		0%
20	Маркетинг, идэвхижүүлэлтийн зардал	18,293.33	9,534.90	52%
21	Зар сурталчилгааны зардал	1,399.65		0%
22	Хөдөлмөр хамгаалалын зардал	21,161.50	27,292.41	129%
23	БУЗ Эм, тариа, түргэн тусламж	1,989.52	2,483.00	125%
24	Бизнес уулзалтын зардал	3,000.00		0%
25	Ажилчдыг идэвхижүүлэх болон баяр ёслол, уралдаан тэмцээний зардал	8,500.00	22,569.00	266%
26	Бэлэг дурсгалын зардал	7,354.86	64.00	1%
27	Бэлэн бүтээгдэхүүний буцаалт зардал	401,768.11	496,594.60	124%
28	Хангамж БҮТЭЗ	12,213.04	6,331.00	52%
29	Дээж шинжилгээтэй холбоотой зардал	4,493.53	6,112.00	136%
30	Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдалаас хамгаалах сан болон хүүгийн зардал	41,177.66	25,685.20	62%
31	Банкны шимтгэл	18,930.08	20,853.40	110%
	Нийт	2,348,164.15	2,103,083.01	89.6%



Мүүрь Аудит ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Олимпийн гудамж 7/3,
Центрум төв 7 давхар, 701 тоот
Утас: +976 7015 0003
Факс: +976 7015 0003
И-мэйл: info@moore-mongolia.mn
www.moore-mongolia.mn

Дугаар В-44124
Огноо 2024.03.15

"АТАР-ӨРГӨӨ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Бид, 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн МА-2023-СТА-42 тоот гэрээний дагуу Атар-Өргөө ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын аудитыг гүйцэтгэх үүрэгтэй.

Гэрээнд заасан хуваарийн дагуу завсар үеийн аудитыг гүйцэтгэсэн бөгөөд аудитын дуусгалтын үеийн ажлыг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлнэ.

Хүндэтгэсэн
MOORE AUDIT
LLC

0019100012
48 → СЕ А4497
УЛААНБААТАР ХОТ

У.ОЮУНЦАА

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

**Атар-Өргөө ХК-ний 2024 он
Эдийн засгийн үзүүлэлт**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө- 2024 он	Гүйцэтгэл- 2024 он	Гүйцэтгэл хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Тн	2,976		
2	Нийт бүтээгдэхүүн	мян.төг	17,617,942		
3	Хүчин чадлын ашиглалт	%	50%		
4	Нийт ажиллагсдын тоо	Хүн	230		
5	Цалингийн сан	мян.төг	3,726,000		
6	Нийт цэвэр борлуулалт	мян.төг	15,573,768		
7	Борлуулалтын өртөг	мян.төг	11,524,588		
8	Нийт ашиг	мян.төг	4,049,180		
9	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	1,245,901		
10	Борлуулалтын зардал	мян.төг	2,336,065		
11	Үйл ажиллагааны ашиг	мян.төг	467,213		
12	Бусад орлого	мян.төг	137,940		
13	Бусад зардал	мян.төг	161,451		
14	Бусад ашиг алдагдал	мян.төг	(23,511)		
15	Тэнцлийн ашиг алдагдал	мян.төг	443,703		
16	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян.төг	443,703		
17	Орлогын албан татвар	мян.төг	44,370		
18	Цэвэр ашиг алдагдал	мян.төг	399,332		
19	Жилийн дундаж цалин /1хүн/	төгрөг	16,200.00		
20	Сарын дундаж цалин /1хүн/	төгрөг	1,350		



Гүйцэтгэх захирал:..... /Ж.Сайнбилэг/

СЭЗА-ны дарга:..... /Ц.Отгондулам/

Эдийн засагч:..... /С.Гантуул/

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт

Төлөөлөн удирдах зөвлөл Атар-Өргөө ХК-ийн 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, Санхүүгийн 2023 оны тайлан, Атар-Өргөө ХК, түүний алба, нэгж, Гүйцэтгэх удирдлага 2023 онд 13,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 189,1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Компани, түүний гүйцэтгэх удирдага төлөвлөгөө, төлөвлөлттэйгөөр үйл ажиллагаагаа зохион байгуулж, эдийн засгийн амаргүй орчинд зах зээлд эзлэх байр сууриа хадгалж авч үлдэх, шинэ бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг татах, өмнөх жилүүдэд нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг 2022 онд дахин баталгаажуулан ISO/IEC 17025-2007 стандартад нийцсэн итгэмжлэгдсэн дотоод лаборатор, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүнд хими, микробиологийн шинжилгээг тогтмол хийж, хэрэглэгч, ард түмэндээ чанарын баталгаатай хүнсээр хангах үүргээ биелүүлэн ажилласан байна.

Хими, нян судлалын лаборатороор итгэмжлүүлж "Сорилтын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" ISO/IEC 17025:2005 олон улсын стандартын гэрчилгээг Стандартчилал Хэмжил Зүйн Газраас “Салбартаа анхдагч” -аар нэвтрүүлсэн байна.

Мөн үйлдвэрлэлийн түүхий эд худалдан авахдаа хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториор баталгаажуулахаас гадна итгэмжлэгдсэн дотоод лабораторт олон төрлийн үзүүлэлтээр шинжилж, стандарт ба техникийн шаардлагад нийцсэн түүхий эдийг олон талаас нь туршилтанд оруулж шаардлага хангасан тохиолдолд үйлдвэрлэлд нэвтрүүлдэг зэрэг юм.

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Гүйцэтгэх удирдлагаас гаргасан тайлантай танилцаад дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

“Атар-Өргөө” ХК-нь:

1. Дотоод, хяналт шалгалтыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн өгөөж, ажил үүргийн хуваарийг нэмэгдүүлсэн.
2. Өмч, хөрөнгө, бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтайгаар үйлдвэрлэлд ашиглахад анхаарч ажилласан.
3. Эрсдэлд суурилсан бодлогын бичиг баримтыг шинэчлэн батласан.
4. Өөрийн хөрөнгөөр шинэ тоног төхөөрөмжүүдээр үйл ажиллагаагаа сайжруулсан, хөрөнгө оруулалтыг зээлээр биш өөрийн хөрөнгөөр шийдвэрлэж, үйлдвэрлэлд шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд хийж гүйцэтгэсэн байна.
5. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахин хамгаалж зөрчилгүй ажиллаж чадсан.
6. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж ажилласан.
7. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн, үйлдвэрлэлийн өгөөжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Энэ талаар гүйцэтгэх захирлаас Төлөөн удирдах зөвлөлд танилцуулж байгаа үйл ажиллагааны тайланд тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг тайландаа бүрэн зөв тусгасан байна гэж үзэж, гүйцэтгэх захирал чиг үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж байна.

Мөн түүнчлэн жил бүрийн бизнесийн төлөвлөгөө бүрэн биелэхгүй байгаад дүгнэлт хийж, бизнес төлөвлөгөөг үндэслэл сайтай биелэгдэхүйц байдлаар боловсруулах шаардлагатай гэж үзэв.

Атар-Өргөө ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа, борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн зардлын харьцааг харгалзан үзэж компанийн цэвэр ашгийн тоон үзүүлэлтийг харгалзан компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэхийг хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлаар шийдвэрлэх болно.

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийг батлах саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуульд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хийх өдрөөр дуусгавар болох, одоо мөрдөж байгаа Компанийн дүрмээр төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн тоог ес, үүнээс хараат бус гишүүний тоог гурав байхаар тогтоосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо дор дурдсан хүмүүсийг Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох нэрийн жагсаалтад тус тус бүртгэн авч, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэрийг нь дэвшүүлсэн тухай шийдвэр гаргасан болно.

“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЕРДИЙН ГИШҮҮНД:

№	ОВОГ НЭР	ТӨГССӨН СУРГУУЛЬ	ТУРШЛАГА
1.	Бэрэнбаралын Мөнхдалай 1962 онд төрсөн.	1986 онд Харьков хотын Политехникийн дээд сургуулийг холбооны электроник, уул уурхайн цахилгаан механик инженерийн мэргэжлээр төгссөн.	<ul style="list-style-type: none"> ➤ 1986-1991 онд Багануурын нүүрсний уурхайд инженерээр, ➤ 1992-1997 онд “Бэрэн” ХХК-д инженер, ➤ 1997-2001 онд “Бэрэн” ХХК-д дэд захирал, ➤ 2005 оноос “Бэрэн майнинг” ХХК-ийн Ерөнхий захирал, ➤ 1997-2011 онд “Атар өргөө” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, ➤ 2012 оноос хойш “Атар өргөө” ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.
2.	Бэрэнбаралын Ганбат 1960 онд төрсөн.	1977-1981 онд ойн техникч, механикч мэргэжилээр 1984-1988	<ul style="list-style-type: none"> ➤ 1983-1986 онд УААЯ-ын авто баазад жолооч, ➤ 1990-2000 онд “Бэрэн” ХХК-д менежер, орлогч захирлаар ➤ 2002 оноос одоог хүртэл “Нэхээсгүй эдлэл” ХК-д Ерөнхий захирлаар ажиллаж байна.
3.	Жамцын Сайнбилэг 1976 онд төрсөн.	1998 онд Орхон дээд сургуулийг англи хэлний орчуулагчаар, 2003 онд СЭЗДС-ийг зээлийн эдийн засагчаар, 2004 онд Шанхай Будан хотын сургуулийг хятад хэлээр	<ul style="list-style-type: none"> ➤ 1999-2002 онд “Атар өргөө” ХК-нд нярав, ➤ 2002-2004 онд “Бэрэн конштракшин анд автотранспорт” ХХК-ийн ня-бо, захирал ➤ 2005-2016 онд “Бэрэн майнинг” ХХК-ийн дэд захирал, ➤ 2016 оноос хойш “Атар өргөө” ХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
4.	Мөнхдалайгийн Мөнхтэнгис 1995 онд төрсөн.	2002-2012 онд Сант бүрэн дунд сургуульд, 2013-2017 онд Австрали улсад University of Queensland сургуулийг хуульч мэргэжлээр	<ul style="list-style-type: none"> ➤ Хувиараа бизнес эрхэлдэг

5.	Ганзоригийн Баттулга 1986 онд төрсөн.	Раффлес олон улсын коллежийг 2012 онд Бизнесийн удирдлагын бакалавраар төгссөн.	<ul style="list-style-type: none"> ➤ 2004-2005 онд “Булган гурил тэжээл” ХК-нд менежер, ➤ 2005-2007 “Булган гурил тэжээл” ХК-нд гүйцэтгэх захирлаар, ➤ 2013-2015 онд Бэрэн металл ХХК-ийн гүйцэтгэх захирлаар, ➤ 2012 оноос “Атар өргөө” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
6.	Дүгэрийн Даваадорж 1967 онд төрсөн.	1992 онд АУИС-ийг хүний их эмч мэргэжлээр, 2004 онд Польш улсын Лоз хотын АУИС-ыг доктор, профессор цолтойгоор,	<ul style="list-style-type: none"> ➤ 1992-2013 онд ЭМСУИС-ийн ахлах багшаар ➤ 2006 оноос ЭМЯамны элэгний эмгэгийн ерөнхий мэргэжилтэнээр, ➤ 2007 оноос УБ, Сонгдо эмнэлэгийн зөвлөх эмчээр, ➤ 2013 оноос Анагаахын үндэсний их сургуулийн дэд захирлаар, ➤ Улсын хавдар судлалын үндэсний төвийн зөвлөх эмчээр, улсын хавдар судлалын үндэсний төвийн зөвлөх эмчээр, ➤ 2008-2014 онд Монголын гастро энтралогийн холбооны дэд ерөнхийлөгчөөр ➤ 2014 оноос Монголын гастро энтралогийн холбооны ерөнхийлөгчөөр,
7.	Ганзоригийн Энхболд 1984 онд төрсөн.	Сити дээд сургуулийн маркетингийн менежер мэргэжлээр төгссөн.	<ul style="list-style-type: none"> ➤ “Бэрэн майнинг” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
8.	Лхагвын Ганпүрэв 1967 онд төрсөн.	УБ Барилгын техник-Барилгын инженерээр, Полтехникийн дээд сургуулийг Барилгын инженерээр, Ядон улс, Хоккайдо хот ХААИС, Отгонтэнгэр их сургуулийг эрх зүйчээр	<ul style="list-style-type: none"> ➤ Улсын барилгын зургийн төв институтэд зургийн техникч ➤ Дархан хот Технизийн их сургуульд –Багш ➤ Дархан “ Мах экспо” ХК-Дэд захирал ➤ “Тайж трейд” ХХК-нд Ерөнхий захирал ➤ “Тайж групп” ХХК-нд Ерөнхий захирал ✓ Аж үйлдвэрийн гавьяат ажилтан ✓ Алтан гадас одон ✓ Хөдөлмөрийн хүндэт медаль ✓ Хүнс ХААН тэргүүний ажилтан ✓ Стандартчлалын тэргүүний ажилтан ✓ Монгол улсын зөвлөх инженер
9.	Зоригбаатарын Төрболд 1995 онд төрсөн.	МУИС-ыг бизнесийн удирдлагын бакалавраар, ШУТИС-ийг санхүү, менежментийн магистраар,	<p>“Стандарт Инвестмент ҮЦК” ХХК</p> <ul style="list-style-type: none"> ➤ 2014-2016 онд брокер ➤ 2016-2018 онд дилер ➤ 2018-2020 Андеррайтер ➤ 2020-оос өнөөг хүртэл Хөрөнгө оруулалтын Зөвлөх, Гүйцэтгэх захирал ➤ 2021 оос өнөөг хүртэл Мерекс ХК-ийн ТУЗ-ын хараат бус гишүүн ✓ МХБ үнэт цаасны тэргүүний ажилтан ✓ СЗХ үнэт цаасны тэргүүний ажилтан ✓ Сангийн яамны жуух бичиг

ХАРААТ БУС ГИШҮҮНД:

№	ОВОГ НЭР	ТӨГССӨН СУРГУУЛЬ	ТУРШЛАГА
1.	Сүхбаатарын Бямбахорол 1982 онд төрсөн.	2003 онд Мандах НББДС—ыг нягтлан бодогч мэргэжлээр, 2005 онд МУИС бизнесийн удирдлагын магистраар,	<ul style="list-style-type: none"> ➤ 2006 онд мэргэшсэн нягтлан бодогч ➤ 2010 онд Монгол улсын аудитор ➤ 2011 онд татварын мэргэшсэн зөвлөх ➤ 2003-2005 онд Тээвэр хөгжлийн банканд нягтлан бодогч, ➤ 2005 оноос одоог хүртэл СЭЗДС-ийн ахлах багшаар ажиллаж байна.

		2015 онд СЭЗДС-ийг бизнесийн удирдлагын доктороор,	
2.	Цолмонгийн Галтаа 1984 онд төрсөн.	2004-2009 онд ОХУ-ын Волгоград хотын Дотоод хэргийн яамны академийг эрх зүйч мэргэжлээр, 2010-2011 онд Сингапур улсын Стэнсфийл коллежийн хуулийн ангийг, 2012-2019 онд МУИС-ын хуулийн сургуулийг магистраар,	<ul style="list-style-type: none"> ➤ Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Гадаад харилцааны мэргэжилтэнээр, ➤ 2019 оноос өмгөөлөгчөөр
3.	Тогоогийн Жигмэддавга 1962 онд төрсөн.	1985-1991 онд ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуулийг,	<ul style="list-style-type: none"> ➤ 1992 оноос Ксенн ХХК-ийн захирлаар, ➤ Ди Си Эф ХХК-ийн ТУЗ-ийн даргаар, ➤ “Атар өргөө” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
4.	Пүрэвийн Болормаа 1979 онд төрсөн.	2002-2006 онд ШУТИС-КТМС-ийг санхүүгийн удирдлага мэргэжлээр,	<ul style="list-style-type: none"> ➤ ИСМА олон улсын боловсролын төвд захирал, Монгол газар ХХК-д хүний нөөцийн менежерээр тус тус ажиллаж байна.
5.	Ганжууржавын Оюун 1951 онд төрсөн.	ЗХУ Москва хотын Хүнсний аж үйлдвэрийн технологийн дээд сургуулийг инженер, технологчоор, ШУТИС –ийн ХИБС –ийг докторантураар	<ul style="list-style-type: none"> ➤ Талхны үйлдвэрт –ажилчин, мастер, цехийн дарга ➤ ХХҮЭШЗТ институтд эрдэм шинжилгээний ажилтан, ерөнхий инженер, секторын эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга ➤ ХЭШҮ-ийн “Хүнстех” корпораци - секторын эрхлэгч, төслийн удирдагч, ЭНБД ➤ ХЭШҮ-ийн “Само” институт- баталгаажилтын байцаагч, Гүйцэтгэх захирал <ul style="list-style-type: none"> ✓ Аж үйлдвэрийн гавьяат ажилтан ✓ Алтан гадас одон ✓ Хөдөлмөрийн хүндэт медаль ✓ Хүнс ХААН тэргүүний ажилтан ✓ Стандартчлалын тэргүүний ажилтан ✓ Шинжлэх ухааны тэргүүний ажилтан

Эдгээр нэр дэвшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 6, хараат бус гишүүнээр 3 хүнийг сонгох бөгөөд тарааж өгсөн саналын хуудсаар тус тусад нь кумулятив аргаар саналаа өгнө үү.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын
хэмжээг тогтоох тухай.**

Компанийн тухай хууль, Компанийн дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний цалин, урамшууллын хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэж байхаар тогтоосон.

Хууль, дүрмийн энэхүү заалтыг үндэслэн тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын төсвийг батлуулахаар оруулж байна.

Тус компанийн дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, 1 нарийн бичгийн даргатай байхаар тогтоосон бөгөөд тэдний сарын цалинг дор дурдсан хэмжээгээр тогтоох санал оруулж байна.

Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшуулал

Албан тушаал	Тоо	Сарын цалин, урамшуулалын хэмжээ (төгрөгөөр)	
		Нэгжийн	Бүгд
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүн	9	660,000	71,280,000
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийн урамшуулал	4	100,000	3,600,000
Нарийн бичгийн дарга	1	1,800,000	21,600,000
Дүн			97.000,000

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД

Тооллогын комиссын тогтоолыг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын “Хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01, “Саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын комиссын

дүнгийн тухай” 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус баталсугай.

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлж ажиллахыг шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, компанийн Дүрмийн “Долоо”-ын 7.22 дахь заалт, хувьцаа эзэмшигчдээс кумулятив аргаар өгсөн санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Дор дурдсан хүмүүсийг Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр - 6
Хараат бус гишүүнээр -3

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллийн төсвийг батлах тухай

Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллийн төсвийг батлах тухай төсвийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллийн зардлын төсөв”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

“АТАР ӨРГӨӨ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай Тогтоолын Хавсралт - 03

**“ АТАР ӨРГӨӨ ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн 14.00 цагт УБ, Хан уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-20, компанийн хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаарРегистрийн дугаар

Санал өгөх хувьцааны төрөл, тооКумулятив саналын тоо

Бүртгэсэн: / БДК-ийн нэр /

Брокерын овог нэр

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт			
2	Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар хэлэлцэн батлах			
3	Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайланг хэлэлцэн батлах			
4	Компанийн 2024 оны төлөвлөгөөг батлах хэлэлцэн батлах			
5	ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох			
6	ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн цалин, урамшууллын дүнг тогтоох			
7	Бусад			

Жич: “Зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” алин болохыг чагтлана / зөвхөн нэгийг нь /

Компанийн ТУЗ-ын гишүүдийг сонгох /санал хураалтын хэлбэр: кумулятив/

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн саналын тоо	Татгалзсан саналын тоо
8	ТУЗ-ын ердийн гишүүдийг сонгох	-	-
	1.		
	2.		
	3.		
	4.		
	5.		
	6.		
9	ТУЗ-ын хараат бус гишүүдийг сонгох	-	-
	1.		
	2.		
	3.		

Хувь нийлүүлэгч / гарын үсэг /

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
2. ТУЗ-ын гишүүдийг сонгох хэлбэр: Кумулятив аргаар - Жишээ нь: хувьцаа эзэмшигч А нь “Б” ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэгэнгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно.
3. Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцохгүй тохиолдолд саналын хуудсаа өөрийн харьяа брокер дилерийн компани дээрээ бөглөж үлдээнэ үү.
4. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын талаартоот утсаар лавлаж болно.

Санал авах хуудсыг хүчингүй болгосон шалтгаан:

.....

